



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/17 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан, хавсралтад заасан нэр бүхий 4 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг компаниудын удирдлагад анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжаа бүртгэлийн алба /Д.Тогтохбаяр/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

Гүйцэтгэх захирлын 2018 оны 2 дугаар сарын
14-ны өдрийн 1/8 тоот тушаалын хавсралт



Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг сэргээх
гишүүн үнэт цаасны компаниудын нэрс

1. "Дэлгэрхангай секюритиз ҮЦК" ХХК
2. "Масдак ҮЦК" ХХК
3. "Тэсо инвестмент ҮЦК" ХХК
4. "Эм ай си си ҮЦК" ХХК

---oOo---